



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2016 оны 9 дүгээр сар


Ерөнхий тойм: Оны эхний 9 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 9.6%-иар буюу 616.9 сая ам.доллараар буурч 5780.8 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 5.9%-иар буюу 208.1 сая ам.доллараар, импорт 14.3%-иар буюу 408.8 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлжээ. Тайлант хугацаанд экспортын дүн импортын дүнгээс 884.8 сая ам.доллараар давж гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 200.7 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 9 сараар			Өөрчлөлт			
	2013	2014	2015	2014/2013		2015/2014		2014	2015	2016	2015/2014		2016/2015	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	10,627	11,011	8,467	384	3.6%	(2,544)	-23.1%	8,044	6,398	5,780.8	(1,646)	-20.5%	(617)	-9.6%
Экспорт	4,269	5,774	4,669	1505	35.3%	(1,105)	-19.1%	4,021	3,541	3,333	(480)	-11.9%	(208)	-5.9%
Импорт	6,358	5,237	3,797	(1,121)	-17.6%	(1,440)	-27.5%	4,023	2,857	2,448	(1,166)	-29.0%	(409)	-14.3%
Тэнцэл	(2,089)	538	872	2,626		335	62.2%	(1)	684	884.8	686		201	29.3%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид нөлөөлдөг суурь хүчин зүйлүүдийн нэг юм. Валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2016 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 889.2 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 10.3 сая ам.доллараар өссөн байна.

Дүрслэл 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 61.1% буюу 3531.4 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 11.4% буюу 657.8 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 12.4%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 30.3%-иар тус тус буурсан байна.

Дүрслэл 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Хүснэгт 2. Худалдааны нөхцөлийн индекс /2012 оны 12 сар суурьтай/

Үнийн индексийн төрөл*	2015.9 сар	2016.8 сар	2016.9 сар	Жил Δ	Сар Δ
Экспорт	0.74	0.68	0.69	-6%	2%
Зэсийн баяж мал	0.35	0.30	0.30	-14%	0.3%
Чулуун нүүрс	0.41	0.38	0.40	-4%	4.2%
Ямааны угаасан ноолуур	0.34	0.31	0.32	-8%	1.8%
Импорт	0.60	0.59	0.58	-4%	-3%
Хэрэглээний бараа	0.78	0.74	0.77	-1%	3%
Хөрөнгө оруулалтын бараа	0.52	0.56	0.51	-2%	-10%
Нефтийн бүтээгдэхүүн	0.58	0.50	0.51	-12%	3%
Худалдааны нөхцөл	1.23	1.15	1.20	-2%	5%

* Индексийн өөрчлөлтөд голлох хувь нэмэр оруулсан бараагаар задлав.

Гадаад худалдааны нөхцөлийн индекс тайлант хугацааны эцэст өмнөх оны мөн үеэс 2.1%-иар буурсан бол, өмнөх сараас 4.7%-иар өсч 1.202-д хүрлээ. Тайлант сард хөрөнгө оруулалтын барааны импортын үнэ буурсан, зэсийн баяжмал, нүүрсний экспортын үнэ өссөнөөс худалдааны нөхцөл өмнөх сараас сайжирсан байна.

Экспорт 2016 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 5.9%-иар буюу 208.1 сая ам.доллараар буурсан. Экспортын бууралтыг ерөнхий ангиллаар задалж үзвэл аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын өсөлт нь нийт экспортыг 2.6 нэгж хувиар өсөхөд нөлөөлсөн бол уул уурхайн түүхий эдийн экспортын бууралт нь нийт экспортыг 7.7 нэгж хувиар буурахад нөлөөлжээ. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 2.7 нэгж хувиар буурсан бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний жин 3.0 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2014			2015			2016			Δ (2015/2014)			Δ (2016/2015)				
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%²	Дүн	Өсөлт	%²		
I. Уул уурхай		3,555	88%		3,080	87%		2,808	84%		(475)	-13%	-12%		(271)	-9%	-8%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	966	1,683	42%	930	1,715	48%	1,198	1,272	38%	32	2%	1%	(443)	-26%	-13%		
1.2. Чулуун нүүрс	13,473	633	16%	9,571	432	12%	16,074	506	15%	(201)	-32%	-5%	73	17%	2%		
1.3. Боловсруулаагүй нефть	5,051	500	12%	5,193	293	8%	5,877	235	7%	(207)	-41%	-5%	(58)	-20%	-2%		
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	4,157	314	8%	3,055	164	5%	4,581	178	5%	(150)	-48%	-4%	13	8%	0%		
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	5,126	214	5%	6,959	286	8%	9,849	399	12%	72	34%	2%	113	40%	3%		
1.6. Цайрын хүдэр, баяжмал	80	90	2%	72	96	3%	98	107	3%	6	6%	0%	11	12%	0%		
1.7. Жоунш, лейцит, нефелинт	228	52	1%	182	47	1%	187	45	1%	(4)	-8%	0%	(2)	-4%	0%		
1.8. Молибдений хүдэр, баяжмал	3	22	1%	3	23	1%	4	18	1%	1	5%	0%	(5)	-21%	0%		
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	1	12	0%	1	11	0%	1	8	0%	(1)	-7%	0%	(3)	-31%	0%		
1.10. Мөнгө /тонн/	42	33	1%	48	10	0%	68	28	1%	(22)	-18%	-1%	18	177%	1%		
1.11. Бусад	18	2	0%	48	1	0%	70	12	0%	(1)	-35%	0%	11	0%	0%		
2. Мал аж, ахуй		308	8%		278	8%		259	8%		(30)	-10%	-1%		(19)	-7%	-1%
2.1. Амьд мал, малын мах	1	3	0%	2	7	0%	4	9	0%	4	147%	0%	2	28%	0%		
2.2. Арьс, шир	230	27	1%	177	23	1%	120	17	1%	(4)	-14%	0%	(6)	-25%	0%		
2.3. Малын өлөн гэдэс	0	7	0%	0	7	0%	0	5	0%	0	2%	0%	(2)	-30%	0%		
2.4. Ноолуур	6	261	6%	6	226	6%	6	211	6%	(34)	-13%	-2%	(16)	-7%	0%		
2.5. Ноос, бусад үс, хялгас	6	11	0%	7	14	0%	11	16	0%	3	29%	0%	2	13%	0%		
2.6. Бусад	0	0	0%	0	0	0%	0	1	0%	0	246%	0%	0	80%	0%		
3. Газар тариалан		17	0%		21	1%		13	0%		5	28%	0%		(9)	-40%	0%
I. Аж үйлдвэрлэл		140	3%		160	5%		252	8%		20	15%	1%		92	58%	3%
4.1. Хүнс	1	4	0%	2	16	0%	5	24	1%	12	301%	0%	8	49%	0%		
4.2. Ноолууран эдлэл	0	18	0%	0	18	1%	0	18	1%	0	1%	0%	0	2%	0%		
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	1	5	0%	0	7	0%	1	11	0%	1	26%	0%	4	63%	0%		
4.4. Уул уурхай	13	33	1%	28	62	2%	22	61	2%	29	91%	1%	(1)	-1%	0%		
4.5. Цахилгаан, электрон бараа	0	4	0%	0	2	0%	0	4	0%	(2)	-50%	0%	2	129%	0%		
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эданги	2	70	2%	1	51	1%	1	127	4%	(19)	-28%	0%	76	150%	2%		
4.7. Бусад	182	6	0%	128	5	0%	179	7	0%	(2)	-26%	0%	2	45%	0%		
5. Бусад		2	0%		2	0%		1	0%		0	6%	0%		(1)	-61%	0%
Нийт дүн		4,021		3,541			3,333			(480)	-12%		(208.1)	-5.9%			

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 4. Экспортын өөрчлөлт, 2016 он

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Уул уурхай	740.1	-273%	(1,011.5)	373%	(271.4)	-9%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	284.6	-64%	(727.7)	164%	(443.1)	-26%
1.2. Чулуун нүүрс	204.5		(131.1)		73.5	17%
1.3. Боловсруулаагүй нефть	27.4	-47%	(85.5)	147%	(58.1)	-20%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	59.2		(45.9)		13.4	8%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	117.1	104%	(4.0)	-4%	113.2	40%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	28.1	247%	(16.7)	-147%	11.4	12%
1.7. Жоунш, лейцит, нефелинт	1.4	-66%	(3.4)	166%	(2.1)	-4%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	5.3	-109%	(10.2)	209%	(4.9)	-21%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	0.3	-8%	(3.7)	108%	(3.5)	-31%
1.10. Мөнгө /тонн/	8.3	46%	9.8	54%	16.2	177%
1.11. Бусад	3.7	35%	6.9	65%	10.6	0%
2. Мал аж, ахуй	13.2	-69%	(32.3)	169%	(19.1)	-7%
2.2. Арьс, шир	(8.3)	148%	2.7	-48%	(5.6)	-25%
2.4. Ноолуур	10.3	-66%	(25.8)	166%	(15.5)	-7%
3. Газар тариалан	(1.2)	14%	(7.3)	86%	(8.6)	-40%
4. Аж үйлдвэрлэл	7.4	8%	84.7	92%	92.1	58%
5. Бусад	(0.1)	6%	(1.1)	94%	(1.1)	-61%
Нийт дүн	759.4		(967.5)		(208.1)	-6%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Дүрслэл 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



2016 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр экспортын гадаад худалдаа тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 759.4 сая ам.доллараар өссөн бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 967.5 сая ам.доллараар буурсан байна. Уул уурхайн түүхий эдийн экспорт тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалан 740.1 сая ам.доллараар өссөн хэдий ч үнийн бууралтаас шалтгаалж 1011.5 сая ам.доллараар буурснаас нийт дүнгээр 271.4 сая ам.доллараар буурлаа. Мал аж, ахуйн түүхий эдийн экспорт үнэ буурснаас шалтгаалж 19.1 сая ам.доллараар буурсан байна. Харин машин, тоног төхөөрөмжийн экспортын өсөлтөөс голлон шалтгаалж аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт 58%-иар буюу 92.1 сая ам.доллараар өсчээ.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2016 оны 9 дүгээр сард 1,327 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 18%-иар өссөн бол өнгөрсөн сараас 0.9%-иар буурчээ. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн үнэ тайлант сард харгалзан 4,722, 58 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 10%-иар буурч, төмрийн хүдэр 1%-иар өссөн бол өнгөрсөн сартай харьцуулахад харгалзан 1%, 5%-иар тус тус буурсан байна. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 9 дүгээр сард 35 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.4%-иар, өмнөх сараас 10.2%-иар тус тус өссөн.

Импорт 2016 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 14.3%-иар буюу 408.8 сая ам.доллараар буурсан. Импортын бууралтыг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 9 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 6 нэгж хувийг тус тус тайлбарлаж байна. Хэрэглээний бүтээгдэхүүний нийт импортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 6 нэгж хувиар өссөн бол нефтийн бүтээгдэхүүний жин 5 нэгж хувиар буурчээ.

Хүснэгт 5. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2014			2015			2016			Δ (2015/2014)			Δ (2016/2015)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
Хэрэглээний бүтээгдэхүүн		1,022	25%		814	29%		859	35%	(208)	-20%	-5%	44	5%	2%
Түргэн эдэлгээтэй	612	547	14%	640	465	16%	577	457	19%	(82)	-15%	-2%	(8)	-2%	0%
Хүнс	290	380	9%	270	318	11%	289	317	13%	(63)	-17%	-2%	(1)	0%	0%
Эм, пүриа	2	56	1%	2	54	2%	2	63	3%	(2)	-4%	0%	9	17%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	320	110	3%	368	93	3%	286	77	3%	(17)	-15%	0%	(16)	-17%	-1%
Удаан эдэлгээтэй	139	476	12%	137	350	12%	102	402	16%	(126)	-26%	-3%	52	15%	2%
Гуулал, хувцас, цүнх	30	43	1%	31	36	1%	38	38	2%	(7)	-17%	0%	2	6%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба твиллаа	52	98	2%	62	70	2%	19	74	3%	(28)	-28%	-1%	4	5%	0%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	1	278	7%	1	196	7%	1	246	10%	(82)	-29%	-2%	50	25%	2%
Бусад удаан эдэлгээтэй бараа	56	56	1%	43	47	2%	45	44	2%	(9)	-16%	0%	(3)	-6%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн		1,670	42%		1,097	38%		839	34%	(574)	-34%	-14%	(257)	-23%	-9%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	19	856	21%	14	566	20%	11	475	19%	(290)	-34%	-7%	(90)	-16%	-3%
Суудлаас бусад твэрийн хэрэгсэл, эд анги	1	225	6%	1	88	3%	0	139	6%	(137)	-61%	-3%	51	59%	2%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	18	631	16%	13	478	17%	10	336	14%	(153)	-24%	-4%	(142)	-30%	-5%
Барилгын материал	2,397	635	16%	1,462	396	14%	597	227	9%	(240)	-38%	-6%	(169)	-43%	-6%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	76	179	4%	60	135	5%	40	137	6%	(44)	-25%	-1%	2	1%	0%
Аж үйлдвэрлэлийн орц		454	11%		391	14%		390	16%	(64)	-14%	-2%	(1)	0%	0%
Хүнсний орц	47	27	1%	34	22	1%	182	49	2%	(5)	-18%	0%	27	126%	1%
Химийн бүтээгдэхүүн	91	71	2%	98	69	2%	86	60	2%	(1)	-2%	0%	(9)	-13%	0%
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	22	11	0%	12	11	0%	20	14	1%	0	1%	0%	3	25%	0%
Цахилгаан эрчим хүч	1	93	2%	1	95	3%	1	91	4%	2	3%	0%	(4)	-4%	0%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	1	0	0%	0	1	0%	1	1	0%	1	150%	0%	0	39%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалт ат	691	252	6%	613	192	7%	585	173	7%	(60)	-24%	-1%	(19)	-10%	-1%
Нефтийн бүтээгдэхүүн		828	864	21%		843	537	19%		733	356	15%	(327)	-38%	-8%
Дизель түнш	485	481	12%	487	288	10%	371	164	7%	(192)	-40%	-5%	(124)	-43%	-4%
АИ-92, АИ-95	229	247	6%	261	172	6%	246	120	5%	(75)	-30%	-2%	(52)	-30%	-2%
А-80 болон бусад	114	137	3%	95	77	3%	116	72	3%	(60)	-44%	-1%	(5)	-6%	0%
Бусад		6	12	0%		16	18	1%		80	4	0%	6	14	0%
Нийт дүн		4,023		2,857		2,448		(1,166)	-29.0%	(408.8)	-14.3%				


%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 6. Импортын өөрчлөлт, 2016 он

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	(12.6)		56.9		44.3	5%
Түргэн эдэлгээтэй	(9.1)	113%	1.1	-13%	(8.0)	-2%
Удаан эдэлгээтэй	(3.6)	-7%	55.8	107%	52.3	15%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	(334.4)	130%	77.1	-30%	(257.3)	-23%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	(162.2)	180%	72.0	-80%	(90.2)	-16%
Барилгын материал	(172.7)	102%	3.7	-2%	(169.0)	-43%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	0.5	25%	1.4	75%	1.9	1%
Аж үйлдвэрлэлийн орц	31.6		(32.5)		(0.9)	0%
Нефтийн бүтээгдэхүүн	(45.7)	25%	(135.0)	75%	(180.8)	-34%
Дизель түнш	(51.6)	42%	(72.3)	58%	(123.9)	-43%
АИ-92, АИ-95	(7.2)	14%	(45.0)	86%	(52.2)	-30%
А-80 болон бусад	13.1	-285%	(17.7)	385%	(4.6)	-6%
Бусад	3.2	-23%	(17.1)	123%	(14.0)	0%
Нийт дүн	(358.1)	88%	(50.7)	12%	(409)	-14%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Дүрслэл 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2016 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр импорт тоо хэмжээний өөрчлөлтөөс голлон шалтгаалж нийт дүнгээр 358 сая ам.доллараар буурчээ. Бүлэг тус бүрээр авч үзвэл хэрэглээний бүтээгдэхүүний импортын тоо хэмжээ буурсан хэдий ч үнэ нэмэгдсэнээс шалтгаалан уг бүлгийн импорт 32.2 сая ам.доллараар өсчээ.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 23%-иар буюу 257.3 сая ам.доллараар буурсан нь уг бүлгийн импортын тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

Харин нефтийн бүтээгдэхүүний импорт 34%-иар буюу 180.8 сая ам.доллараар буурчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2013 оноос эхлэн тогтмол буурч байна. Хилийн үнэ 2012 оны 12 сард тонн тутамд 1,270.5 ам.доллар байсан бол 2016 оны 9-р сарын байдлаар тонн тутамд 499.0 ам.долларт хүрээд байна.